

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.14 №30 (30)

ҮЙЛ ЯВДАЛ



Эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлыг батлан хамгаалах үйл хэрэгт нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэж, монгол цэргийн дайчин уламжлалаа эрхэмлэн хүндэтгэж, Зэвсэгт хүчнийхээ хөгжил дэвшлийн төлөө нэгэн зорилгын дор мөр зэрэгцэн алба хааж байгаа эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид, эх орноо төлөөлөн хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид Та бүхэндээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлэе.

Ардын хувьсгалыг эхлүүлж, Халхын голд эх орноо хамгаалж, Чөлөөлөх дайнд элэг нэгтнээ өмгөөлж, Баруун хилд зэвсэгт дээрэмчдийг бут цохисон Зэвсэгт хүчин ард түмнийхээ хайр, талархлыг хүлээн баатарлаг өвөг дээдсийнхээ үйл хэргийг нэр төртэй залгамжилсан төдийгүй өнөөдөр ч хуулиар хүлээсэн олон талт үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ даян дэлхийд энх тайвныг бэхжүүлэн нэр алдраа цуурайтуулж, улс орны бүтээн байгуулалтыг гүйцэтгэсээр байна.

Сүүлийн өдрүүдэд улс төр, ард иргэдийн шүүмжлэлд чамгүй дарагдав, бид. Арга ч үгүй байх. Зэвсэгт хүчин гэдэг нийгмийн толь, эх оронч үзэл сэтгэлгээ, сахилга бат, ёс суртахуунаараа хамгийн шилдэг залуусын цугласан салбар гэж тэд хүлээн зөвшөөрсөн учраас бухимдал, шүүмжлэлээ хатуухан илэрхийлэв гэж харж байна. “Монгол Улсынхаа төлөө зүтгэе” хэмээн тангараглаж

зогссон сайхан цэрэг хүүгээ эх орон нь алдаж, цэргийн дарга, онжавууд нь өнчирсэн мэт сэтгэл хөндүүр байгаа ч бидэнд төлөвшиж, хүмүүжээгүй зарим нөхдийн алдааг засаад явах нь өнөөдөр юу юунаас илүү чухал байна. Зарим хүний яриад байгаачлан “яргалал” гээч цэргийнхэнд байдаг гэсэн буруу ойлголтыг түгээсэн тэдгээр нөхдийн алдааг та бид үүрэг, хариуцлагаараа засах ёстой.

Шулс, хөлс асар их ялгаатай гэдгийг санаж, шүүмжлэл бүрт эмзэглэж гудайхгүйгээр Зэвсэгт хүчний хөгжил, шинэчлэлийн төлөө зөвхөн урагшаа алхаж, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа нь болж, улс орны их бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийг урагшуулан даян дэлхийн энх тайван, бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах болно. Сүүлийн жилүүдэд Батлан хамгаалах салбарын багц хуулиудад нийцүүлэн Зэвсэгт хүчний үйл ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэн боловсронгуй болгох, тэдгээрийг амьдрал, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилт, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, улс орны бүтээн байгуулалтад оролцох, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар бид багагүй ололт, амжилттай ажиллаж байна.

Бид эх орноо батлан хамгаалах үндсэн үүргээсээ гадна 2002 оноос дэлхийн халуун цэгүүдэд энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж, 2018 оноос улс орны бүтээн

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭР ХҮНДИЙГ ӨНДӨРТ ӨРГӨХ НЬ МӨРДЭСТЭЙ БҮХНИЙ ҮҮРЭГ

байгуулалтад гар бие оролцож, тив дэлхийд “Монгол цэрэг үүрэг гүйцэтгэлт, сахилга бат, зохион байгуулалтаараа шилдгийн шилдэг” хэмээн гайхагдаж, “Үүрэг өгөхөд үгүй гэж хэлдэггүй цэргийнхэн гайхамшигт бүтээн” хэмээн бүтээн байгуулалтад оролцогч цэрэг дайчдыг олон нийт үнэлэн дүгнэж, талархал илэрхийлж байна.

Даян дэлхийд энх тайвныг сахиулж, эх орондоо бүтээн байгуулахын зэрэгцээ алба хаагчдынхаа оюунлаг сэтгэлгээнд “дөрөөлөн” зэвсэглэл, техникийн шинэчлэл, сэргээн сайжруулалтыг бид өнгөрсөн жилд гүйцэтгэж, батлан хамгаалахын үйлдвэрлэлийн суурийг амжилттай тавьж чадлаа. Бидний хамтдаа бүтээсэн түүх баялаг бөгөөд хөлс, хөдөлмөр, хүчин чармайлтаар бий болсон амжилт юм. Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг төлөвшүүлэх, үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, чадавхыг нэмэгдүүлэх зэрэг цаг үеийн шаардлагаар дэвшигдэн гарч буй томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд Зэвсэгт хүчинд алба хааж байгаа хэн бүхний идэвх оролцоо, дэмжлэг, бүтээлч хөдөлмөр нэн чухал юм. Жирийн нэгэн байлдагчаасаа Жанжин штабын дарга хүртэл эрхэлсэн албандаа эзэн нь болж, хөдөлмөр, зүтгэлийг эрхэмлэж, хамтран зүтгэгч нөхдийнхөө хүчин чармайлтыг дэмжиж, бас хүндэтгэх ёстой. Хүндэтгэж байна гээд бялдуучилна гэсэн үг биш. Чармайж буй хүний дэргэд дэмждэг хүн байж, ажил урагшлах учиртай. Хүндлэл хүндлэлийг дагуулдгийг, хөдөлмөр, хүчин чармайлт амжилт дагуулдгийг санаж, өөрийн эрхэлж байгаа ажил албандаа бүтээлч ханд, өгөгдсөн даалгаврыг сайтар биелүүл, тэгээд манлайл.

Зэвсэгт хүчний хөгжлийн гол цөм болсон бие бүрэлдэхүүн Та бүхэнд дараах зарчмуудыг онцгойлон захъя.

Нэгдүгээрт, эх орноо батлан хамгаалж, Зэвсэгт хүчний нэр хүнд, чадавхыг нэмэгдүүлэхийн тулд цэргийн алба, сахилга хариуцлагыг бэхжүүлж, улам хариуцлагатай байцаа. Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөж явах нь мөрдэстэй хүн бүхний үүрэг. Энэ үүрэг та бидний бүгдийнх нь нуруун дээр яваа гэдгийг ухамсарлаж, ажил алба, нийгмийн харилцаа, амьдрал ахуй гээд алхам тутамдаа хариуцлагатай бай. Цэргийн өдөр тутмын үйл ажиллагаа зөвхөн дүрмийн хүрээнд явагдах бөгөөд энд нэг үеийн онжав, найз нөхөд байна уу огт хамаагүй. Дүрмээр харьцаж, дүрмээр ажилла. Нийгмийн салбарын толь, үлгэрлэгч болж яваагийн хувьд үйлдлээрээ үргэлж зөв

байж, дээд дарга нь дэргэдэх цэргээ цэргийн ёсоор захирч, хүний ёсоор хайрладаг бай.

Хоёрдугаарт, өөрийгөө хөгжүүл. Эрүүл мэнд, бие бялдар, эрдэм мэдлэг, сэтгэл зүйгээ бэлтгэ. Хэрэв аль нэг нь хангалтгүй байгаа бол яг өнөөдрөөс бэлтгэ. Сурахад хэзээ ч оройдтоггүй. Харин оролдлого хийдэггүй хүнд ололт, амжилт холоос хол явдгийг санах хэрэгтэй. Ажлын байран дээрх цаг ашиглалтыг дээшлүүлж, хувийн сахилга бат, зохион байгуулалтаа сайжруулах хэрэгтэй байна. Зэвсэгт хүчний хөгжлийн амин сүнс нь бие бүрэлдэхүүний хөгжил, тэдний төлөвлөлт, байгууллагын зөв тогтсон соёлоос шууд хамааралтай юм. Хувь хүн болон байгууллагын хөгжилд бүтээлч сэтгэлгээ хамгаас чухал байна. Мөрөөдөл тэмүүлэл, өөдрөг сэтгэл, хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр, цөхрөлтгүй оролдлого, ажилсаг бүтээлч чадвар энэ бүгд бүтээлч хүнд зайлшгүй байх шилдэг чанар.

Гуравдугаарт, цэргийн бэлтгэл сургалтаа улам төгөлдөржүүл. Сайжруул. Цэрэг хүний үндсэн хөдөлмөр бол бэлтгэл сургалт бөгөөд энэ хөдөлмөр цэргийн алба хаагчийн хөгжих, мэргэших хэрэгцээг хангахад чиглэгдэх ёстой. Тайван цагт хөлс их асгавал дайны цагт цус бага урсана гэсэн мэргэн үг байдаг. Байнгын бэлтгэл сургуулилалт, сэтгэл зүйн төлөвшил нь ямар ч хүнд сорилтод бэлэн байх чадварыг бий болгохын зэрэгцээ улс орноо батлан хамгаалах үүргээ хариуцлагатайгаар биелүүлэхийн үндсийн үндэс гэдгийг ямагт сана. Бэлтгэл сургалтыг дагаад хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг ягштал мөрд. Зөвхөн бэлтгэл сургалтаар хязгаарлагдахгүйгээр өөрийн болон нөхрийнхөө аюулгүй байдлыг үргэлж хамгаал. Цар тахлын халдварын тархалтаас ч гэсэн та өөрийгөө, гэр бүлээ, хамт олноо хамгаалаарай.

Эцэст нь бахархал болсон албаа эрхэмлэж, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүрэгтээ их амжилт үзүүлж, чадварыг эрхэмлэсэн үйл ажиллагааг улам бүр идэвхжүүлэн урагшаа тэмүүлэн ажиллахыг Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд уриалж байна.

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай!

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
+8	-9
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
+36	+24
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
+21	+9

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.364.00	3.424.00
CNY	433.50	436.90
RUB	36.30	37.90
JPY	25.74	26.24
KRW	2.45	2.58

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 2
2021.04.14.
/ЛХАГВА ГАРАГ/

ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ САРЫН ГУРВАН ХӨХ ХАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:
Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх:
06.05-19.40
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй
Суудал:
Гал.

Аргын тооллын 4 дүгээр сарын 14, Буд гараг. Билгийн тооллын 2, Гоё хүүхэн одтой, хар луу өдөр. Өдрийн наран 6 цаг 05 минутад мандан, 19 цаг 40 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандаж хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лус тахих, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөө байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦЭРГИЙН ЦАГДААГИЙН ОЙРЫН ИРЭЭДҮЙ

Монгол Улсад 1924 оны 11 дүгээр сард Цэргийн зөвлөлийн хурлын тогтоолоор Нийслэл хүрээний цэргийн комендантын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн, цагдаа сэргийлэхийн үүрэгт ажлаас салгаж Цэргийн Явдлын Яамны шууд удирдлагад Нийслэл Улаанбаатар хотын “Цэргийн комендант”-ыг байгуулснаар цэргийн цагдаагийн суурь тавигдаж саяхныг хүртэл энэ нэршилээрээ олон нийтэд танигдаж үүргээ гүйцэтгэж иржээ. Олон улсын цэрэг-аюулгүй байдлын орчинд болж буй үйл явдлууд, Зэвсэгт хүчний хөгжил, цаг үеийн өөрчлөлтөөс шалтгаалан хуучин нэршил, гүйцэтгэх үүрэг нь өөрчлөгдөн олон улсын жишигт нийцсэн “Цэргийн цагдаа”-гийн салбар, нэгжийг байгуулж гүйцэтгэх үүрэг, цаашдын чиг хандлагыг тодорхойлох шаардлага бий

болоод байна. ЗХЖШ-ын даргын 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А/9 дүгээр тушаалаар “Цэргийн цагдаа-2030” хөгжлийн хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрт Цэргийн цагдаагийн чиг үүргийг Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэмд дэлгэрэнгүй тусган, хууль эрх зүйн орчинг тодорхой болгож, цаашид Цэргийн цагдаа нь тайван цагийн бүтэц, зохион байгуулалтаараа хууль, тогтоомж, цэргийн дүрмүүдийг мөрдүүлэх, цэргийн хүрээ, хотхон, анги салбар, цэргийн багт цэргийн ёс зүй, сахилга, дэг журмыг сахиулж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх байнгын бэлтгэлтэй, олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн алба болж бэхжинэ.

(Үргэлжлэл нь II нүүрт)



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
15718+885	9516+371	27+2

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
1679 (6)	304	1369

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 135,646,617
Эдгэрсэн	Нийт: 110,419,454
Нас барсан	Нийт: 2,930,732

ЦЭРГИЙН ЦАГДААГИЙН ОЙРЫН ИРЭЭДҮЙ

(Түрүүч нь I нүүрт)

Мөн хуулиар хүлээсэн болон тусгай үүрэг гүйцэтгэх, олон улсын энхийг дэмжих ажиллагаанд бие даан оролцож шаардлагатай үед үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий бусад байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин ажиллах нэгж болон өргөжнө гэж тодорхойлсон. Ингэснээр Цэргийн цагдаа нь төрийн цэргийн байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, осол зөрчлөөс сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, Монгол Улсын хууль, Цэргийн нийтлэг дүрмүүдийн заалтуудыг цэргийн хүрээ, хотхон, анги, байгууллага, салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг гүйцэтгэх юм.

Цэргийн цагдаа нь бэхжсэнээр цэргийн хүрээ, хотхон, анги салбар, цэргийн багийн үйл ажиллагааг хэвийн явуулахад

дэмжлэг үзүүлж гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэргийн байрлал бусад тусгай объектуудын харуул хамгаалалт, түүний шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, цэргийн цувааны аюулгүй байдлыг хангах салбар, нэгжтэй болж улмаар энхийг дэмжих ажиллагаанд бие даан оролцож хүмүүнлэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх, бусад улсын цэргийн цагдаатай хамтран ажиллах, сургалт дадлага зохион байгуулах, харилцан туршлага солилцох боломж нээгдэнэ. Цэргийн цагдаа нь Үндэсний аюулгүй байдлыг хангахад Зэвсэгт хүчнээс хуульд заасны дагуу Цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, үүссэн цагийн байдлыг даамжруулахгүйгээр хяналтдаа байлгаж, хэв журам сахиулахад нэн чухал салбар болох нь олон улсын практик, энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургагмаас харагдаж байна. Улмаар Цэргийн цагдаагийн үйл ажиллагаа жигдэрснээр Зэвсэгт хүчинд үйлдэгдэж байгаа гэмт

хэрэг, осол зөрчлийн тоо багасаж, иргэн-цэргийн харилцаанд Цэргийн цагдаа холбогч үүрэг гүйцэтгэж, Зэвсэгт хүчний нийгмийн хариуцлага, эрх зүйн соёлд шинэ төлөвшил бий болох юм.

Цэргийн цагдаагийн алба хаагчдад тавигдах шаардлагыг шинээр тодорхойлж, Зэвсэгт хүчний офицер ахлагч, цэргийн гэрээт албаны түрүүч, байлдагч, хугацаат цэргийн алба хаагчид тэмүүлэн ажиллах алба болж, цаашид Цэргийн цагдаа нь Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүндийг улс орондоо төдийгүй олон улсын хэмжээнд өндөрт өргөж, эх орон, Зэвсэгт хүчин, Цэргийн цагдаагийн албаараа бахархах итгэл үнэмшилтэй, ёс суртахуун, бие бялдрын өндөр төлөвшилтэй, шилдэг алба хаагчдаар эгнээгээ бүрдүүлсэн мэргэжлийн хууль, дэг журам сахиулах алба болж хөгжих ирээдүй ойрхон байна.

ЗХЖШ-ЫН ЦЭРГИЙН АЛБАНЫ ХЭЛТЭС

ЦАХИМ ШУУДАНД

ЦЭРЭГТЭЙГЭЭ СПОРТООР ӨРСӨЛДЛӨӨ

Зэвсэгт хүчний 150 дугаар анги

Хээрийн гаралт, полигоны дадлагыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр ангийн аварга шалгаруулах цэрэгжлийн спортын 3 төрлийн уралдаан тэмцээнд 9 салбараас давхардсан тоогоор 212 цэргийн алба хаагч хамрагдав. Мөн бие бүрэлдэхүүнд кино үзүүлэх, дартсын аварга шалгаруулах тэмцээн зэргийг зохион явууллаа.

Ангийн мэргэжлийн оны аварга офицер, ахлагч, эмэгтэй цэргийн алба хаагч шалгаруулах марш тактик, тусгай бэлтгэлийн тэмцээнд офицеруудын төрөлд 16 офицер өрсөлдсөнөөс ахлах дэслэгч С.Сүхболд, ахмад Б.Зоригтбаатар, ахлах дэслэгч Ц.Тэмүүлэн нар эхний байруудад шалгарсан юм. Ахлагчийн төрөлд 116 ахлагч өрсөлдсөнөөс дэд ахлагч С.Даваадалай, ахлагч Г.Ганзориг, О.Мөнхсүрэн, эмэгтэй цэргийн алба хаагчдын төрөлд ахлагч Э.Ариунзул, Б.Болормаа, ахлах ахлагч В.Одмаа нар тус тус шалгарав.

Цэрэгжлийн буудлагын тэмцээнийг гар буу, автомат, мэргэн буудагчийн винтовын ангиллаар явууллаа. Тэмцээнд 8 багийн 40 тамирчин өрсөлдсөнөөс эрэгтэй гар бууны тогтоол буудлагын төрөлд ахмад Э.Үүрийнцолмон, ахлах ахлагч Н.Өлзийжаргал, хурандаа Г.Ялалт, эмэгтэй төрөлд хошууч Н.Туяа, ахлах ахлагч В.Одмаа, ахлагч Б.Болормаа нар эхний гурван байрыг эзлэв. Мөн эрэгтэйчүүдийн автоматын тогтоол буудлагын төрөлд ахмад Б.Мөнхбуян, гранатын төрөлд ахлагч Б.Баасандорж, ахлах ахлагч Д.Алтанхуяг, П.Гансүх, эмэгтэйчүүдийн төрөлд ахлагч Э.Ариунзул, ахлах ахлагч В.Одмаа, сургагч ахлагч Д.Нэргүй, мэргэн буудагчийн винтовын төрөлд ахлах ахлагч Б.Найдансүрэн, ахмад Э.Ганбат, ахлах ахлагч Ч.Баярсайхан нар тус тус шилдгээр шалгарлаа.

Цэргийн 3 төрөлтийн тэмцээнд



7 багийн 56 тамирчин өрсөлдсөнөөс буудлагын төрөлд ахлагч Б.Баасандорж, З.Ариунболд, ахмад Б.Мөнхбуян, гранатын төрөлд ахлагч Б.Баасандорж, ахлах ахлагч Э.Бямбацогт, ахлагч Д.Жавхланбаатар, гүйлтийн төрөлд дэд ахлагч М.Сауыржан, ахлагч М.Мөнхбаатар, Ч.Март нар эхний байруудад шалгарч, нийлбэр дүнгээр ахлагч Д.Жавхланбаатар, Б.Баасандорж, ахмад Б.Мөнхбуян нар бусдыгаа тэргүүлээ. Багийн дүнгээр мотобуудлагын IV, II ротууд бусдыгаа

манлайлав.

Мөн бие бүрэлдэхүүний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, тэдэнд дартсын спортыг сурталчлан таниулах зорилгоор явуулсан тэмцээнд 24 тамирчин өрсөлдсөнөөс ахмад Б.Мөнхбуян захирагчтай мотобуудлагын II рот, ахмад Б.Зоригтбаатар захирагчтай миномётын батарей, III байрт байлдааны хангалт, материал техник хангалтын салбарын хамтарсан баг тус тус шилдгээр шалгарлаа.

Ахмад Г.БИЛГҮҮН

ЦАХИМ УУЛЗАЛТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Б а т л а н хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, Зэвсэгт хүчний анги, байгууллагын харилцан ажиллагааг хангах, цэрэг дайчдыг ар гэрийнх нь тухай мэдээ мэдээллээр хангах зорилгоор цахим уулзалтыг зохион байгууллаа.

2020 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагаар тус дүүргээс цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 016

дугаар нэгтгэл, 338 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдыг ар гэртэй нь цахимаар "уулзуулав". Тус арга хэмжээнд оролцсон эцэг эхчүүд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, алба хааж буй хөвгүүддээ албаа нэр төртэй хаахыг захиж байлаа.

ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЯН ӨРНҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн удирдлага, хамт олон энэ сарын 8-ны өдрөөс долоо хоногийн хугацаатай дархлаажуулалтын аяныг эхлүүлээ.

Аяны хүрээндангийнэмнэлгийн

албанаас бие бүрэлдэхүүнд С, Д амин дэм болон аарц, чацарганыг өгч Улсын онцгой комиссоос гаргасан "Covid-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг өдөр тутмын амьдралдаа хэвшил болгохыг уриалж байна.

Ахмад Н.МӨНХБААТАР

ТУСГАЙ УТАС АЖИЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Хугацаат цэргийн албанд татагдан ирсэн түрүүч, байлдагчдыг ар гэрийнхэнтэй нь цахим орчинд уулзуулах арга хэмжээ хуваарийн дагуу зохион байгуулагдаж байна.

Энэ удаад нийслэлийн Хан-Уул дүүргээс татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдын уулзалтыг зохион байгуулж, ангийн захирагч хурандаа А.Болдбаатар түрүүч, байлдагчдын амьдрал үйл ажиллагааг танилцуулж, "Цэргийн алба хаагчийн нэг өдөр" видео нэвтрүүлгийг үзүүлэн ар гэрийнхнийг нь сонирхсон асуултад хариулав.

Түүнчлэн энэ өдрөөс эхлэн 88579336 дугаарын утсыг ажиллуулж эхэлснийг мэдэгдлээ.

Дэслэгч Ч.БОДЬГЭРЭЛ

ХЭЭРИЙН ГАРАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 330 дугаар анги

Хээрийн гаралт, полигоны дадлагыг амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр мотобуудлагын тасаг, салаа, хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын салааны байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг хамтатган зохион байгуулснаараа онцлог болов. Мөн бие бүрэлдэхүүнийхээ онолын мэдлэгийг дадлагаар баталгаажуулж, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 8 төрлийн соёл, олон нийтийн ажлыг зохион байгуулсан юм.

Дэслэгч Х.МӨНХ-ЭРДЭНЭ